



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 4/29

Улаанбаатар хот

“Цусаа бэлэглэж, цохилох зүрх бүхнийг аваръя”
аян зарлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Донорын тухай хуулийн 21 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цусаа бэлэглэж, цохилох зүрх бүхнийг аваръя” идэвхжүүлэлтийн 3 сарын аяны удирдамжийг 1 дүгээр, дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдамж, төлөвлөгөөний дагуу Цусны салбар төвүүд хариуцсан нутаг дэвсгэртээ тус аяныг зохион байгуулж, тайлан ирүүлэхийг Цусны салбар төвийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2021 оны 6 дугаар сарын 2-ны
өдрийн 2/29 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

1118260548 0128905

“ЦУСАА БЭЛЭГЛЭЖ ЦОХИЛОХ ЗҮРХ БҮХНИЙГ АВАРЪЯ” 3 САРЫН АЯНЫ УДИРДАМЖ

Улаанбаатар хот

НЭГ. Үндэслэл

Дэлхий нийтэд цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээ, хангамж улс орон бүрт харилцан адилгүй байна. Ялангуяа хөгжиж байгаа орнуудад цус цусан бүтээгдэхүүний хомсдол хурцаар тулгарч байна. Жил бүрийн 6 дугаар сарын 14-нд “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг тэмдэглэдэг бөгөөд энэхүү өдрийн гол зорилго нь аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний амин чухал хэсэг болох цус цусан бүтээгдэхүүний нөөц хангамж, авлагагүй сайн дурын цусны донорын хөдөлгөөнийг олон нийтэд улам бүр таниулан сурталчилахад оршдог. Энэ жилийн компани ажлын тусгайлсан чиглэл нь аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг бүрдүүлэхэд залуучуудын үүрэг оролцоог онцолж байна. Ихэнх улс орнуудад сайн дурын, авлагагүй цусны донорын үйлсээр дамжуулан аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх зорилго бүхий төрөл бүрийн санаачилга, арга хэмжээнд залуучууд тэргүүн эгнээнд оролцож байна.

Цусны донорууд нь өдөр бүр сая сая хүний амь насыг авран тэдний эрүүл мэндийг дэмжиж, амьдралын чанарыг нь дээшлүүлж байна. Хэдийгээр Коронавирүст (Ковид-19) халдварын цар тахлын үед хүн амын зорчих хөдөлгөөнийг хязгаарласныг үл харгалзан цусны донорууд цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ тасралтгүй өгсөөр байгаа юм. Урьдчилан тааварлахын аргагүй хямралын энэ үед сайн зохион байгуулагдсан, хүсэл зориг дүүрэн, сайн дурын авлагагүй цусны доноруудын ариун үйлсээр аюулгүй, хангалттай цусны нөөцийг тайван болон яаралтай үед бүрдүүлж байна.

Коронавирүст (Ковид-19) халдварын цар тахлын нөхцөл байдлын улмаас цус, цусан бүтээгдэхүүний нөөц буурч байгаатай холбогдуулан Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс хувь хүн, нийгэм, олон нийт, хамтрагч байгууллагуудад хандсан сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх 3 сарын аяныг зохион байгуулж байна.

ХОЁР. Зорилго

Цар тахлын үед болон улирлын хамааралтай цусны нөөц буурахаас урьдчилан сэргийлэх, авлагагүй сайн дурын цусны донорын үйлсийг сурталчлан таниулах

ГУРАВ. Зорилт

- Цар тахлын үед цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээ, ач холбогдлыг олон нийтэд таниулах;
- Авлагагүй сайн дурын цусны донорын үйлсийг олон нийтэд сурталчлах ажлыг идэвхжүүлэх, хүн амын цусны донорын талаарх мэдлэг хандлага дадлыг сайжруулах

ДӨРӨВ. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- Мэдээлэл сургалт сурталчилгааг сошиал орчинд олон талт хэлбэрээр зохион байгуулах
- Олон удаа цусаа бэлэглэсэн цусны донорыг алдаршуулах
- Цусны донорын үйлсийн талаар Эссе бичлэг, гар зургийн уралдаан зохион байгуулах
- Цусны донорын эгнээг өргөжүүлэхэд хувь хүн, хамт олны оролцоог нэмэгдүүлж, идэвхижүүлэх
- ЦССҮТ-ийн бүх алба тасаг, орон нутгийн цусны салбар төвүүд шинэлэг ажлуудыг санаачлан хэрэгжүүлэх, тайлагнах

ТАВ. Хэрэгжих хугацаа

2021 оны 6 дугаар сарын 03-аас 9 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл;

ЗУРГАА. Аяны санхүүжилт

Аяныг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилтийг байгууллагын төсөв, МУЗН, Эрүүл мэндийг дэмжих сан, хандивлагч байгууллагын хандиваар санхүүжүүлнэ.

ДЭЛОО. Хамтран хэрэгжүүлэх байгууллага


Эрүүл мэндийн яам, МУЗН, Эрүүл мэндийг дэмжих сан, Төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, хамт олон

НАЙМ. Шагнал, урамшуулал

9 дүгээр сарын 03-ны өдрийн сар бүрийн 3 Цусаа бэлэглэх өдрийн арга хэмжээний үеэр аяныг дүнг танилцуулж, идэвхтэй оролцсон хувь хүн, байгууллагыг ивээн тэтгэгчийн шагналаар шагнаж урамшуулна.

ЕС. Хүлээгдэж буй үр дүн

- Хүн амын дунд цусны донорын талаарх мэдлэг, хандлага, дадал сайжирна.
- Цар тахлын онцгой нөхцөл байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний шаардлагатай нөөц бүрдэж эмнэлгийн хэрэглээг бүрэн хангах боломж бүрдэнэ.



Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн

1. Ч.Батболд /Захиргаа, маркетингийн албаны дарга, ахлагч/
Гишүүд:
 1. Я.Тогтохням /Хүний нөөцийн ажилтан, хуулийн зөвлөх/
 2. А.Түвшин /Бичиг хэргийн эрхлэгч, архивын ажилтан/
 3. Г.Мөнхсоёл /Статистикч, эдийн засагч/
 4. Б.Мөнгөнтуул /Маркетинг, олон нийттэй харилцах менежер/
 5. О.Тогтохбаяр /Донор зохион байгуулалтын тасгийн эмч/
 6. А.Ананд /Нэгдсэн лабораторийн тасгийн биоанагаахын мэргэжилтэн/
2. Ч.Тунгалаг /Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч, ахлагч/
Гишүүд:
 1. Ё.Улсболд /Донор зохион байгуулалтын тасгийн технологич эмч/
 2. Х.Мядагмаа /Донор зохион байгуулалтын тасгийн технологич эмч/
 3. Г.Цэндбаяр /Донор зохион байгуулалтын тасгийн технологич эмч/
 4. /Эрдэм шинжилгээ мэдээллийн технологийн албаны Мэдээллийн технологийн инженер/
 4. Б.Буянтогтох /Донор зохион байгуулалтын технологич сувилагч/
 5. Ц.Батцэцэг /Донор зохион байгуулалтын технологич сувилагч/
 6. Э.Дашгарав /Донор зохион байгуулалтын технологич сувилагч/
 7. Д.Дулмаа /Маркетинг, нийгмийн эрүүл мэндийн ажилтан/
3. Н.Янжиндулам /Эрдэм шинжилгээ мэдээллийн технологийн албаны дарга, ахлагч/
Гишүүд:
 1. М.Мэндбаяр /Сургалт, төслийн ажилтан/
 2. Н.Өлзийсахйан /Чанарын менежер, халдвар судлаач эмч/
 3. Х.Жавзандулам /Тооцооны нягтлан бодогч/
4. Ч.Далайцэрэн /Эрдэм шинжилгээ мэдээллийн технологийн албаны мэдээллийн технологийн инженер, ахлагч/
Гишүүд:
 1. Н.Батцэрэн /Донор зохион байгуулалтын технологич сувилагч/
 2. Э.Золбоо /Донор зохион байгуулалтын технологич сувилагч/
 3. А.Номин-Өлзий /Үйлдвэрлэлийн тасгийн технологич сувилагч/
5. Б.Өнөрцэцэг /Сувилахуй үйлчилгээний албаны дарга, ахлагч/
Гишүүд:
 1. Д.Эрдэнэтунгалаг /Донор зохион байгуулалтын технологич сувилагч/
 2. Х.Чулуунцэцэг /Донор зохион байгуулалтын технологич сувилагч/
 3. Д.Энхсүрэн /Нэгдсэн лабораторийн тасгийн лаборант/
 4. Б.Золгэрэл /Үйлдвэрлэлийн тасгийн технологич сувилагч/
 5. П.Цэндхүү /Үйлдвэрлэлийн тасгийн технологич сувилагч/

6. Ц.Өлзийхишиг/ Сувилахуй үйлчилгээний тасгийн үйлчилгээний ажилтан/

6. Н.Баяртогтох /Нэгдсэн лабораторийн тасгийн эмч, ахлагч/

Гишүүд: 1. М.Цэрэндэжид /Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч/

2. Д.Сайра /Нэгдсэн лабораторийн тасгийн лаборант/

3. Н.Тэрбиштогтох /Нэгдсэн лабораторийн тасгийн лаборант/

4. С.Ганчимэг /Нэгдсэн лабораторийн тасгийн лаборант/

5. Д.Энхсүрэн /Нэгдсэн лабораторийн тасгийн лаборант/

7. Б.Оргил /Үйлдвэрлэлийн тасгийн технологич эмч, ахлагч/

Гишүүд: 1. Н.Халиун /Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч/

2. А.Номин-Өлзий /Үйлдвэрлэлийн тасгийн технологич сувилагч/

3. Б.Золгэрэл /Үйлдвэрлэлийн тасгийн технологич сувилагч/

4. Б.Дуламсүрэн /Үйлдвэрлэлийн тасгийн технологич сувилагч/

5. Н.Энхтуул /Үйлдвэрлэлийн тасгийн технологич сувилагч/

8. Ц.Энхмэнд /Инженер техникийн тасгийн эрхлэгч, ахлагч/

Гишүүд: 1. Б.Додьгалсан /Инженер техникийн тасгийн тоног төхөөрөмжийн инженер/

2. Ж.Эрхэмбаяр /Инженер техникийн тасгийн слесар, туслах ажилтан/

3. А.Энхбаатар /Инженер техникийн тасгийн слесар, туслах ажилтан/

4. Б.Есүүн /Донор зохион байгуулалтын тасгийн сувилагч/

5. Б.Долормаа /Үйлдвэрлэлийн тасгийн технологич сувилагч/

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2021 оны 6 дугаар сарын 2-ны
өдрийн 4/29 дугаар тушаалын
3 дугаар хавсралт

1118266548 0126805

“ЦУСАА БЭЛЭГЛЭЖ, ЦОХИЛОХ ЗҮРХ БҮХНИЙГ АВАРЪЯ” 3 САРЫН АЯНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уриа: Цусаа бэлэглэж, цохилох зүрх бүхнийг аваръя!

Д/д	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэгч	Шаардагдах нөөц
Чиглэл 1. Мэдээлэл сургалт сурталчилгааг сошиал орчинд олон талт хэлбэрээр зохион байгуулах					
1.	Аяны үйл ажиллагааг олон нийтэд зарлах	6 сарын 3	Ч.Батболдын дэд ажлын хэсэг	Цусны салбар төв	
2.	Олон нийтэд хандсан Уриалга гаргах /Эрүүл мэндийн сайд/	6 сарын 14	Т.Алимаа	Цусны салбар төв	
3.	Аяны албан ёсны аннонс-1 том , баннер-3 төв явуул 1, хөлтэй самбар-5ш, жижиг зургийн хүрээ 4ш бэлтгэх, тогтмол сурталчилах	6 сарын 3-5	Ч.Далайцэрэнгийн дэд ажлын хэсэг	Санхүү, бүртгэлийн алба Цусны салбар төв	Төсөв гаргаж, санхүүжилтийг шийдвэрлэх
4.	Цахим аннонс дээр дэмжигч байгууллагуудын логог байршуулж өдөр тутам шинэчлэх, түгээх /веб сайт, пейж, твиттер, фейсбүүк, инстаграм, челленж/	Аяны турш	Ч.Далайцэрэнгийн дэд ажлын хэсэг	Бүх ажиллагсад Цусны салбар төв	
5.	Аяны үйл ажиллагааг тогтмол сурталчлах /аяны үргэлжлэх хугацааг цахим тоолох	Аяны турш	Б.Өнөрцэцэгийн дэд ажлын хэсэг	Цусны салбар төв	

				Г.Мөнхсоёл	
6.	Олон нийтийн мэдээллийн самбараар аяны аннонс байршуулж нийтэд мэдээлэх /байгууллага, нийслэлийн самбар, автобусны буудал, орон сууцны лифт г.м/	Аяны турш	Ч.Батболдын дэд ажлын хэсэг	Б.Оргилын дэд ажлын хэсэг Н.Баяртогтохын дэд ажлын хэсэг Цусны салбар төв	Төсөв гаргаж, санхүүжилтийг шийдвэрлэх
7.	Аяны явцын талаарх хэвлэлийн мэдээлэл бэлтгэж, түгээх	7 хоног тутам	Ч.Батболдын дэд ажлын хэсэг	Цусны салбар төв	
Чиглэл 2: Олон удаа цусаа бэлэглэсэн цусны донорыг алдаршуулах					
8.	Тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэх, цусны донорыг алдаршуулах	6 сарын 3, 6 сарын 14, 7 сарын 3, 8 сарын 3, 9 сарын 3	Ч.Батболдын дэд ажлын хэсэг	Ч.Тунгалагын дэд ажлын хэсэг Цусны салбар төв	
9.	Аяны хугацаанд шилдэгүүдийг шалгаруулж алдаршуулах /ивээн тэтгэгч байгууллага, донор хамт олон, цусны донор, цусны донорын үйлсийг сурталчлагч ... г.м/	Аяны турш	Ч.Тунгалагын дэд ажлын хэсэг	Б.Өнөрцэцэгийн дэд ажлын хэсэг Цусны салбар төв	Төсөв гаргаж, санхүүжилтийг шийдвэрлэх
10.	Жил бүрийн номинацад шалгарсан шилдэгүүдийг сурталчлах	Аяны турш	Б.Өнөрцэцэгийн дэд ажлын хэсэг	Б.Оргилын дэд ажлын хэсэг Н.Баяртогтохын дэд ажлын хэсэг Цусны салбар төв	
Чиглэл 3: Цусны донорын эгнээг өргөжүүлэхэд хувь хүн, хамт олны оролцоог нэмэгдүүлж, идэвхижүүлэх					

11.	Цусаа бэлэглэх челленж зохион байгуулах /байгууллага, хувь хүн/	Аяны турш	Ч.Тунгалагын дэд ажлын хэсэг	Бүх ажлын хэсэг Цусны салбар төв	
12.	Уриа бүхий бугуйвч /боолт/ цусаа бэлэглэсэн доноруудад түгээн, бусдыг уриалах	Аяны турш	Ч.Батболдын дэд ажлын хэсэг	Ч.Тунгалагын дэд ажлын хэсэг Цусны салбар төв	Төсөв гаргаж, санхүүжилтийг шийдвэрлэх
13.	Цусны донорын үйлсийн талаар гар зургийн уралдаан зохион байгуулах	7 сарын 3	Б.Өнөрцэцэгийн дэд ажлын хэсэг	Ивээн тэтгэгч байгууллага Цусны салбар төв	Төсөв гаргаж, санхүүжилтийг шийдвэрлэх
		8 сарын 3			
14.	Цусны донорын үйлсийн талаар Эссе бичлэгийн уралдаан зохион байгуулах	7 сарын 3 8 сарын 3	Н.Янжиндуламын дэд ажлын хэсэг	Ивээн тэтгэгч байгууллага Цусны салбар төв	Төсөв гаргаж, санхүүжилтийг шийдвэрлэх
15.	Олны танил хүмүүсийг Цусаа бэлэглэх үйлсэд татан оролцуулах /сайн дурынханыг бэлтгэх, ажлуулах	Аяны турш	Ч.Батболдын дэд ажлын хэсэг	Бүх ажлын хэсэг МУЗН	
16.	“Олон нийтэд танигдсан” газруудад явуулын багаар цус цуглуулах, олон нийтийг хамруулах	14 хоног тутам	Ч.Батболдын дэд ажлын хэсэг	Ч.Тунгалагын дэд ажлын хэсэг Цусны салбар төв	

Боловсруулсан: Цусны донорын Дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг